
**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН
ТООЦООНЫ ТАЙЛАН**

[Марч легал эдвайс ХХК]

АГУУЛГА

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

- 1.1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох
- 1.2. Хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэг, стандарт үйл ажиллагааг тодорхойлох
- 1.3. Зардлыг тооцох
- 1.4. Тоон үзүүлэлтийг тооцох
- 1.5. Нийт зардлыг тооцож гаргах
- 1.6. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах
- 1.7. Нэмэлт зардлыг тооцох

ХОЁР. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

- 2.1. Гарах зардлыг урьдчилан тооцоолох
- 2.2. Зардлыг нэгтэн тооцох
- 2.3. Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

ГУРАВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

- 3.1. Төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох
- 3.2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох
- 3.3. Гарах зардлыг урьдчилан тооцоолох
- 3.4. Нийт зардлыг тооцож гаргах
- 3.5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

ДӨРӨВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэрэгжүүлэх нэмэлт чиг үүрэг бий болгож байгаа эсэхэд үнэлгээ хийн үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэж байгаа болно.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн зардлыг тооцохдоо тус хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү ар талын газар, Бодлого төлөвлөлтийн газраас гаргаж өгсөн судалгаа, тоо баримт, статистикийг ашигласан болно.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2.1-д заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг тодорхойлох;
2. Зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
5. Хялбарчлах боломжийг ашиглах;
6. Нэмэлт зардлыг тооцох.

1.1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт хуулийн этгээдийн хүлээх үүргийг тогтоож өгсөн бөгөөд Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд шинээр үүрэг болгосон зүйл, хэсэг, заалт байхгүй боловч, чиг үүрэгт хамаарах дараах зохицуулалт байна гэж үзэж сонгон авч тооцоо хийлээ.

Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл, хэсэг, заалт

№	Хуулийн төсөл дэх шинээр үүрэг хүлээлгэсэн зохицуулалт
1.	8.4.Уул, уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллага баталж, хяналт тавина.
2.	14.3.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардагдах мэдээ, мэдээллийг холбогдох төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авна.

Хуулийн төслийн 8.4 дэх хэсэг нь Онцгой байдлын байгууллагын эрх хэмжээнд хамаарах боловч, нөгөө талаар уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн

этгээд нь уул уурхайн аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Онцгой байдлын байгууллагаар батлуулах үүрэг хүлээж байна.

1.2. Хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэг, стандарт үйл ажиллагааг тодорхойлох

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн төлөвлөгөө боловсруулах стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших “ Баруун ноён уул уурхайн ” нүүрсний ил уурхайн 2025 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг үндэслэсэн болно.

Хүснэгт 2. Чиг үүрэг, стандарт үйл ажиллагаа

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Уул, уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд	Уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд нь уул уурхайн аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах	- Төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээг тодорхойлох -Компаний байршил, бодлого, үйл ажиллагааны талаар танилцуулга бэлтгэх -Компанийн ажиллах хүчин, албан тушаалын судалгаа гаргах -Уурхайн геологи болон геотехникийн нөхцөлийг тодорхойлох -Хяналтын ажлын төлөвлөгөө боловсруулах -Уурхайн зохион байгуулалт болон тоног төхөөрөмжийн мэдээллийг гаргах -Уурхайд гарч болзошгүй аваар осол, түүнийг арилгах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох -Хүний үйл ажиллагаатай холбоотой үүсч болзошгүй осол эрсдэлээс хамгаалах арга хэмжээг тодорхойлох -Аваар осол тулгарсан үед хэрэгжүүлэх шуурхай ажиллагааны журам боловсруулах -Аваар устгах төлөвлөгөө болон түүний схемийн байршлыг гаргах -Аваар, ослын үед нийт ажиллагсдын баримтлах зарчим, хүлээх үүргийг тодорхойлох -Зарлан мэдээлэл, харилцаа холбоог зохион байгуулах журам, схем боловсруулах -Зарлан мэдээлэл, харилцаа холбоог зохион байгуулах журам, схем боловсруулах -Нийт ажиллагчдын холбоо барих утасны жагсаалтыг гаргах

		-Шатах тослох материалын тооцоо судалгаа гаргах -Уул уурхайн машин, техникийн судалгаа гаргах -Холбогдох хавсралтуудыг гаргах -Төлөвлөгөөг нэгтгэж, удирдлагын багаар хянуулах
	Уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд нь уул уурхайн аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллагаар батлуулах	-Төлөвлөгөө батлуулах талаар албан бичиг үйлдэх -Төлөвлөгөөг хэвлэж олшруулах -Төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллагаар хянуулах -Онцгой байдлын байгууллагын хяналтын үр дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт оруулах -Төлөвлөгөөг эцэслэн хэвлэж, удирдлагаар хянуулах -Төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллагад хүргүүлж батлуулах
Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төсөл дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд	Гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардагдах мэдээ, мэдээллийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад үнэ төлбөргүй гаргаж өгөх	-Үүрэгтэй танилцах, судлах -Холбогдох мэдээлэл цуглуулах -Маягт бөглөх, тэмдэглэх -Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах -Алдааг нягтлаж засах -Тоо баримт боловсруулах -Дотоод хуралдаан зөвөлгөөн -Удирдлагын багаар хянуулах -Мэдээлэл шилжүүлэх -Төрийн захиргааны байгууллагаас шалгах -Төрийн захиргааны байгууллагын шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт -Холбогдох байгууллагатай харилцахад хүндрэл үүссэнээс үүдэн мэдээлэл нэмж цуглуулах

1.3. Зардлыг тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана. Хуулийн этгээдийн зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоох шаардлагатай.

Зардлыг тооцохдоо дараах хүчин зүйлийг харгалзан үзэв. Үүнд:

1. Үйлдэл буюу стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг тогтоох;
2. Тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлох.

Үйлдэл буюу стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацааг тогтооход хуулийн этгээдийн Уул уурхайн аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад хийгдэх үйл ажиллагаа, Уул уурхайн аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулахад

хийгдэх үйл ажиллагаа нэг бүрийг ямар хугацаанд хийж гүйцэтгэхийг дунджаар гаргасан стандарт хугацаагаар тооцно.

Тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлохдоо хуулийн этгээдэд ажиллаж буй нэг ажилтны сарын дундаж цалин хөлсийг баримжаалан тооцох бөгөөд зарим тохиолдолд тусгай мэдлэг, мэргэжил, ур чадвар шаардсан үйл ажиллагаанд өндөр цалин, хангамж олгож буй тохиолдлыг анхаарч авч үздэг.

Мөн нэг сард ажиллах хугацааг тооцож гарган үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааснаар тухайн ажилтанд ногдох ажлын хөлсийг тооцож гаргана.

Хүснэгт 3. Уул уурхайн салбарт ажиллагчдын сарын дундаж цалин¹

Он	2022	2023	2024
Дундаж цалин	4333.2	5125.6	5402.8

Хэмжих нэгж: мян.төг

2024 оны 14 дүгээр улирлын байдлаар уул уурхайн олборолтын салбарын ажилтан сард дундажаар 5,402,800 төгрөгийн цалин авч байгааг Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаанд дурдсан байна. Иймд хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотой ажлын хөлсийг тооцоолохдоо Үндэсний статистикийн хорооноос гаргасан дээрх судалгааг эх сурвалж болгон ашигласан.

Уул уурайн салбарт ажиллагсдын сарын дундаж цалин сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол өссөн үзүүлэлтэй байгаа бөгөөд 2024 оны дундаж цалинд үндэслэн ажилтны нэг сарын ажлын хөлсийг 5,402,800 төгрөг байхаар, ажиллах хугацааг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цаг 8 цагаас илүүгүй байхаар тооцлоо.

Үүнээс харахад нэг ажилтан нэг сард ажлын 22 өдөр/22*8=176 цаг, 176*60=10560 минут/ ажилладаг байна.

Үндсэн цалин / Ажиллах хугацаа = Ажлын хөлс /төгрөг/

5,402,800 / 176 цаг = 30,697 төгрөг /цагт/

5,402,800 / 10560 минут = 511 төгрөг /мин/

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр= ажлын 8 цаг

1 цаг = ажлын 60 минут

Хүснэгт 4. Уул уурхайн салбарын хуулийн этгээдийн ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар

№	Ерөнхий үйл ажиллагаа	Хугацаа /минут/	Ажлын хөлс /төгрөг/	Зардал /төгрөг/
Уул уурхайн аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах				
1.	Төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээг тодорхойлох	60	511	30660
2.	Компаний байршил, бодлого, үйл ажиллагааны талаар танилцуулга бэлтгэх	1	511	511
3.	Компанийн ажиллах хүчин, албан тушаалын судалгаа гаргах	0	511	0

¹ https://downloads.1212.mn/TYz7i07B_fpy5sqmWOAjlH3N_-D-0Fn-nj_hmW_.pdf

*Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөлд хийсэн зардлын тоонооны тайлан*

4.	Уурхайн геологи болон геотехникийн нөхцөлийг тодорхойлох	1440	511	735840
5.	Хяналтын ажлын төлөвлөгөө боловсруулах	960	511	490560
6.	Уурхайн зохион байгуулалт болон тоног төхөөрөмжийн мэдээллийг гаргах	0	511	0
7.	Уурхайд гарч болзошгүй аваар осол, түүнийг арилгах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох	1440	511	735840
8.	Хүний үйл ажиллагаатай холбоотой үүсч болзошгүй осол эрсдэлээс хамгаалах арга хэмжээг тодорхойлох	1440	511	735840
9.	Аваар осол тулгарсан үед хэрэгжүүлэх шуурхай ажиллагааны журам боловсруулах	960	511	490560
10.	Аваар устгах төлөвлөгөө болон түүний схемийн байршлыг гаргах	1440	511	735840
11.	Аваар, ослын үед нийт ажиллагсдын баримтлах зарчим, хүлээх үүргийг тодорхойлох	1440	511	735840
12.	Зарлан мэдээлэл, харилцаа холбоог зохион байгуулах журам, схем боловсруулах	1440	511	735840
13.	Нийт ажиллагчдын холбоо барих утасны жагсаалтыг гаргах	1	511	511
14.	Шатах тослох материалын тооцоо судалгаа гаргах	60	511	490560
15.	Уул уурхайн машин, техникийн судалгаа гаргах	0	511	0
16.	Холбогдох хавсралтуудыг боловсруулах	1440	511	735840
17.	Төлөвлөгөөг нэгтгэж, удирдлагын багаар хянуулах	120	511	61320
Уул уурхайн аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллагаар батлуулах				
1.	Төлөвлөгөө батлуулах талаар албан бичиг үйлдэх	10	511	5110
2.	Төлөвлөгөөг хэвлэж олшруулах	30	511	15330
3.	Төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллагаар хянуулах	1440/1	511	511
4.	Онцгой байдлын байгууллагын хяналтын үр дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт оруулах	960	511	490560
5.	Төлөвлөгөөг эцэслэн хэвлэж удирдлагаар хянуулах	60	511	30660
6.	Төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллагад хүргүүлж батуулах	60	511	30660
Зарцуулах нийт хугацаа, зардал		13363	511	6,828,493

Хуулийн төслийн 14.3 дахь хэсэгт зааснаар холбогдох төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардагдах мэдээ, мэдээллийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үнэ төлбөргүй гаргаж өгөх үүрэг хүлээж байна.

Гамшгийн үеийн шийдвэр гаргалт, төлөвлөлт, сэргээн босгох болон гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдэд зайлшгүй шаардагдах орон зайн өгөгдөл, мэдээллийг “суурь” гэсэн тодотголоор Онцгой байдлын байгууллага хэрэглэж ирсэн. Гамшгийн үеийн удирдлагын нэгдсэн системд дараах мэдээллүүд нь суурь болон ашиглагдана. Үүнд:

Байр зүйн болон хиймэл дагуулын зураг, хил зааг, хяяг, барилга, газар ашиглалт, тээврийн сүлжээ, хөрс, ус зүй зэрэг нийт 17 төрлийн мэдээлэл, ой, хээрийн болон объектын гал түймэр, үер, ган, зуд, хүчтэй цасан болон шороон шуурга, газар хөдлөлт, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин зэрэг гамшгийн төрлүүдтэй холбоотой мэдээллийг холбогдох төрийн захиргааны байгууллага, хуулийн этгээдээс Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

Иймд уг хэсгийг хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцох хэсэгт оруулсан болно.

Хүснэгт 5. Хуулийн төслийн 14.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийн ажиллагчдын сарын дундаж цалин²

Байгууллага	Төсөвт байгууллага	Хувьцаат компани	Төрийн өмчит үйлдвэрийн газар	Хязгаарлагдмал хувьцаат компани
Дундаж цалин	2690.2	2960.9	3246.1	2616.2
Дундаж цалин: 2878.4				

Хэмжих нэгж: мян.төг

Дээрх байгууллагуудад ажиллагсдын нэг сарын дундаж цалинг 2024 оны статистикт үндэслэн 2,878,400 төгрөг байхаар, ажиллах хугацааг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цаг 8 цагаас илүүгүй байхаар тооцлоо.

Үндсэн цалин / Ажиллах хугацаа = Ажлын хөлс /төгрөг/

2,878,400 / 176 цаг = 16,354 төгрөг /цаг/

2,878,400 / 10560 минут = 272 төгрөг /мин/

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр= ажлын 8 цаг

1 цаг = ажлын 60 минут

Хүснэгт 6. Хуулийн төслийн 14.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийн ажилтны сарын ажлын хөлсийг цаг, минутаар

№	Ерөнхий үйл ажиллагаа	Хугацаа /минут/	Ажлын хөлс /төгрөг/	Зардал /төгрөг/
1.	-Үүрэгтэй танилцах, судлах	120	272	32640
2.	-Холбогдох мэдээлэл цуглуулах	120	272	32640

² https://downloads.1212.mn/TYz7i07B_fpy5sqmWOAjlH3N_-D-0Fn-nj_hmW_.pdf

3.	-Маягт бөглөх, тэмдэглэх	30	272	8160
4.	-Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	45	272	12240
5.	-Алдааг нягтлаж засах	60	272	16320
6.	-Тоо баримт боловсруулах	120	272	32640
7.	-Дотоод хуралдаан, зөвөлгөөн	60	272	16320
8.	-Удирдлагын багаар хянуулах	60	272	16320
9.	-Мэдээллийг шилжүүлэх	10	272	2720
10.	-Төрийн захиргааны байгууллагаас хянах	60	272	16320
11.	-Төрийн захиргааны байгууллагын хяналтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт оруулах	90	272	24480
12.	-Холбогдох байгууллагатай харилцахад хүндрэл үүссэнээс үүдэн мэдээлэл нэмж цуглуулах	120	272	32640
Зарцуулах нийт хугацаа, зардал		895	272	243,440

1.4.Тоон үзүүлэлтийг тооцох:

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хэчнээн хуулийн этгээдэд, жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

2025 оны хагас жилийн байдлаар Монгол Улсад нийт 2,720 хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгаагаас хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 962, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 1,758 хуулийн этгээд бүртгэлтэй байна.³

2025 оны байдлаар уул уурхайн олборолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 268 хуулийн этгээд аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Уул уурхайн аврах 09 дүгээр ангиар хянуулж батлуулсан байна. Иймд тохиолдлын тоог уул уурхайн олборолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн тоог 268-аар, давтамжийн тоог жилд 1 удаа байхаар тус тус тооцов

Тоон үзүүлэлт нь хуулийн үйлчлэлд хамаарах бүх хуулийн этгээдэд үүсэх нийт зардлыг тооцоолоход ашиглах ач холбогдол бүхий тоон утга юм. Үүнийг дараах томъёогоор гаргана.

Тоон үзүүлэлт=Тохиолдлын тоо×Давтамж тоо

Хүснэгт 7. Хуулийн этгээдийн тоон үзүүлэлтийг тодорхойлох нь /хуулийн төслийн 8.4 дэх хэсэг/

д/д	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	х	Давтамж	=	Тоон үзүүлэлт
-----	-----------------	----------------	---	---------	---	---------------

³ Монголын уул уурхайн салбарын судалгаа. 2025-II улирал

1	Уул, уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд нь аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Онцгой байдлын байгууллагаар хянуулж, батлуулна.	268	x	1	=	268
---	--	-----	---	---	---	-----

Тохиолдлын тоо нь тухайн үүргийг нийт хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг харуулдаг бол давтамжийн тоо нь тухайн үүргийг хуулийн этгээд 1 жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг харуулна.

Хуулийн төслийн 14.3 дахь хэсэгт заасан гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардагдах мэдээ, мэдээллийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үнэ төлбөргүй гаргаж өгөх үүрэг хүлээсэн төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн тоон үзүүлэлтийг дараахь байдлаар тодорхойлов.

Гамшгийн мэдээллийн сан, гамшгийн үеийн удирдлагын нэгдсэн систем бүрдүүлэхэд холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж зэрэг байгууллага, хуулийн этгээдээс мэдээллийг систем холбох байдлаар болон цахимаар (Хиймэл дагуулын мэдээ, сансрын холбооны ириудум, үүрэн холбоо) авна.

Мэдээллийг жилд 1 удаа, сар бүр, тухайн гамшгийн нөхцөл байдал үүссэн үед зэрэг янз бүрийн давтамжтай авах бөгөөд тохиолдлын тоог тогтоох боломжгүй тул давтамж болон тохиолдлын тоог жилд 1 удаа нэг байгууллагаас авахаар тооцов.

Хүснэгт 8. Хуулийн этгээдийн тоон үзүүлэлтийг тодорхойлох нь /хуулийн төслийн 14.3 дахь хэсэг/

д/д	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	x	Давтамж	=	Тоон үзүүлэлт
1	Гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардагдах мэдээ, мэдээллийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үнэ төлбөргүй гаргаж өгөх	1	x	1	=	1

1.5. Нийт зардлыг тооцож гаргах:

Энэ хэсэгт, өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж /**Нийт зардал=Зардал×Тоон үзүүлэлт**/ нийт захиргааны зардлын дүнг гаргана.

Хүснэгт 9. Нийт зардлын дүн

д/д	Гүйцэтгэх үүрэг	Зардал	x	Тоон үзүүлэлт	=	Нийт зардал ⁴
1.	Уул, уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд нь аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Онцгой байдлын байгууллагаар хянуулж, батлуулна.	10,782,100	X	268	=	2,889,602,800

⁴ “Нийт зардал” гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх нийт хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал юм.

2.	Гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардагдах мэдээ, мэдээллийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үнэ төлбөргүй гаргаж өгөх	243,340	X	1	=	243,340
----	--	---------	---	---	---	----------------

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд хуулийн этгээдэд дээрх зардал үүсэхээр байна. Тус зардал нь хуулийн этгээдийн тооноос шууд хамааралтай болохыг дурдах нь зүйтэй.

1.6. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

1.6.1.Аргачлалын 2.7.1-д заасны дагуу хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:

Энэ тохиолдолд хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй байна. Учир нь манай улсад уул, уурхайн үйлдвэрлэлийн салбарыг дагаад энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн тоо цаашид нэмэгдэх магадлалтай, ялангуяа сүүлийн жилүүдэд бичил уурхай эрхлэгчдийн тоо нэмэгдэж байна.

1.6.2.Аргачлалын 2.7.2-т заасны дагуу мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах, боломж байгаа эсэх:

Хуулийн төсөлд зааснаар, тухайн хуулийн этгээд уул уурхайн үйлдвэрлэлийн үе шатанд ямар нэг осол, аваар аюул тохиолдсон үед түүний хор уршийг арилгах үйл ажиллагааг төлөвлөж жилдээ 1 удаа Онцгой байдлын байгууллагаар хянуулж батлуулах үүрэг хүлээсэн. Энэ нь гарч болох аливаа эрсдэлийг бууруулах, гарсан тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай хамтран шуурхай хариу арга хэмжээ авах, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, цаашлаад тухайн хуулийн этгээдийн бизнесийн тогтвортой үйл ажиллгааг хангах зэрэг чухал ач холбогдолтой арга хэмжээ юм. Мөн уул уурхайн олборлолт нь нарийн технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандарт шаарддаг, эрсдэл өндөртэй үйл ажиллагаа юм. Иймд мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах нь хуулийн төслийн зорилтод нийцэхгүй гэж үзэж байна.

1.6.3.Аргачлалын 2.7.3-т заасны дагуу мэдээллийн агуулгыг багасгах, боломж байгаа эсэх:

Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө нь хүний амь нас,эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг зохицуулах удирдлагын баримт бичиг тул мэдээллийг багасгах боломжгүй юм.

1.6.4.Аргачлалын 2.7.4-т заасны дагуу шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна” гэж, 8.2-т “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна гэж, 8.3-т Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан. Мөн Хуулийн этгээдийн эрх, үүргийг зохицуулж буй 34 дүгээр зүйлийн 34.2.1-т “гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталаж хэрэгжүүлэх” гэж заасан. Хуулийн төслийн заалт нь зөвхөн уул, уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд хамаарч байгаа бөгөөд гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлахаас гадна аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Онцгой байдлын байгууллагаар

хянуулж батлуулах үүргийг хуульд шинээр нэмж байгаа юм. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө нь ялгаатай тул гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй нэгтгэх боломжгүй байна.

1.6.5.Аргачлалын 2.7.5-д заасны дагуу мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:

Мэдээллийг хянаж батлуулах үе шатанд цахимаар хүргүүлж хянуулах бүрэн боломжтой байна.

1.6.6.Аргачлалын 2.7.6-д заасанчлан мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх:

Мэдээллийг зөвхөн нэг байгууллага буюу Онцгой байдлын байгууллагаар л хянуулж батлуулах тул мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжгүй гэж үзлээ.

1.6.7.Аргачлалын 2.7.7-д заасан нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх:
Нэг цэгийн үйлчилгээг бий болгох боломжгүй гэж дүгнэлээ.

1.7. Нэмэлт зардлыг тооцох:

Энэ хэсэгт, тус хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийн улмаас хуулийн этгээдэд бусад төрлийн нэмэлт зардал гарахгүй гэж тооцоолов.

ХОЁР. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдэд үүрэг болгосон дараахь зохицуулалт байна.

51 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт	51.5.Гамшиг, ослын шинжгүй, ахуйн дуудлагаар ажилласан томилгоот шуурхай бүлгийн зардлыг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд хариуцан төлнө.
--	--

Энэхүү заалт нь төрөөс гарч буй үргүй зардлыг багасгах зорилготой бөгөөд Онцгой байдлын байгууллага нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 44.1-д зааснаар гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулгүй сэргээн босгох, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй.

Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой 24 цагаар үүрэг гүйцэтгэж буй гал унтраах, аврах анги, салбарын томилгоот нэгжүүд нь гамшиг, ослын бус ахуйн шинжтэй дуудлагад маш ихээр явж байна. Тухайлбал, 2024 онд нийслэл Улаанбаатар хотод гал түймрийн 1911 дуудлага, 2025 онд 2432 дуудлага Онцгой байдлын байгууллагад ирсэн байна. Аврах ажиллагааны дуудлага 2024 онд 488, 2025 онд 589 ирсэн⁵.

Гал түймрийн дуудлага мэдээллийн 4-5%-ийг иргэдийн хайхрамжгүй, хариуцлагагүй байдлын улмаас шалтгаалсан шаардлагагүй дуудлага эзэлдэг бол 1.5-2% нь хуурамч дуудлага эзэлж байна. 2024-2025 онд нэг удаагийн дуудлагад дунджаар 37.5 минут зарцуулсан, үүний улмаас нийт 117 удаагийн шаардлагагүй дуудлагад 73 цагийг үр ашиггүйгээр зарцуулсан байна.

Аврах ажиллагааны дуудлагын 6-8% нь цас, шаварт автомашинтай суусан, 7-11% нь голын усанд автомашинтай суусан, 1% нь голын мөс цөмөрсөн, 6-8% нь хаалга онгойлгох дуудлага эзэлж, 2024-2025 онд нэг удаагийн дуудлагад дунджаар 1 цаг 15 минут зарцуулсан бөгөөд үүний улмаас нийт 66 цагийг үр ашиггүйгээр зарцуулсан байна.

Энэ нь тухайн томилгоот нэгжийн цалин хөлс, техник, багаж хэрэгслийн элэгдэл хорогдол, тээврийн хэрэгслийн шатахуун зэрэг маш их хэмжээний үргүй зардлыг Онцгой байдлын байгууллагад бий болгож байна.

⁵ Нийслэлийн онцгой байдлын газар

Иймд олон улсын жишгийг даган ахуйн шинжтэй дуудлагад үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд гарсан зардлыг хүсэлт гаргасан байгууллага, иргэн хариуцахаар хуулийн төсөлд тусгасан.

Хүснэгт 10. Зардалд нөлөөлөх зүйл, хэсэг, заалт

№	Иргэний гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Төрийн байгууллагын стандарт үйл ажиллагаа
1	51.5.Гамшиг, ослын шинжгүй, ахуйн дуудлагаар ажилласан томилгоот шуурхай бүлгийн зардлыг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд хариуцан төлнө.	- Дуудлага мэдээлэл бүртгэж авах - Томилгоот бүлэгт дамжуулах - Томилгоот бүлэг газар орон дээр очих -Дуудлага, хүсэлтийн дагуу тусламжийн үйл ажиллагаа явуулах -Ажил үүрэг гүйцэтгэсэн тухай маягт бөглөх, бөглүүлэх -Ангийн байрлалд буцах

2.1.Зардлыг урьдчилан тооцох

Хүснэгт 11. а/ Томилгоот шуурхай бүлгийн 1 удаагийн ахуйн дуудлагаар 1 цаг гарч ажиллахад үүсэх зардлын тооцоо

Албан тушаал	Хүний Тоо	Үндсэн цалин	Нэмэгдэл	Хоол		ЭМД шимтгэл 2%	1 сарын цалин хөлс нийт дүн	1 өдрийн цалин	1 цагийн цалин
				өдөрт	сард				
Бүлгийн дарга-1	1/ ТТ-7	1,633,000	1,273,740	15,000	120,000	60,535	3,087,275	140,330.7	17,541.3
Жолооч, холбоочин	1/ ТТ-7	1,633,000	1,208,420	15,000	120,000	59,228	3,020,648	137,302.2	17,162.8
Аврагч	6/ ТТ-8	9,330,000	6,904,200	15,000	720,000	339,084	17,293,284	786,058.4	98,257.3
Дундаж цалин	1	1,574,500	1,173,295	15,000	120,000	57,355	2,925,151	132,961,4	16,620.7

б/ Аврах ажиллагааны дуудлагаар ашиглах багаж хэрэгслийн элэгдэл хорогдол

№	Багаж зэвсэглэмж	Нэгж үнэ	Ашиглах хугацаа	Жилийн элэгдэл	Өдрийн элэгдэл	Цагийн элэгдэл
1	Тэлэгч /Батерей/	50,440,000.0	5	10,088,000	27,638	3,455
2	Тасдагч /Батерей/	49,380,000.0	5	9,876,000	27,058	3,382
3	Олон үйлдэлт багаж /батерей/	49,088,000.0	5	9,817,600	26,898	3,362
4	Олон үйлдэлт багаж /гар ажиллагаатай/	37,688,000.0	5	7,537,600	20,651	2,581
Дүн				37,319,200	102,244	12,781

в/ Аврах ажлын дуудлагаар үүрэг гүйцэтгэх автомашины шатахууны тооцоо

д/д	Автомашин	Чиглэл	Хоорондын зай/км/	100 км-т зарцуулах шатахуун	Нэг бүрийн үнэ /ДТ/	Мөнгөн дүн	1 цагт 80 км явна.
1	Ланд-78	Дуудлагаар ажиллах газар	100	18	3370	60,660	48,528
Дүн			100				48,528

г/ Аврах ажлын дуудлагаар үүрэг гүйцэтгэх автомашины элэгдэл хорогдол

д/д	Автомашин	Нэгж үнэ	Ашиглах хугацаа	Жилийн элэгдэл	Өдрийн элэгдэл	Цагийн элэгдэл
1	Ланд-78	192,000,000	10	19,200,000	52,603	6,575
Дүн				19,200,000	52,603	6,575

2.2.Зардлыг нэгтгэх тооцох

Томилгоот бүлгийн үүрэг гүйцэтгэхэд зарцуулсан зардлыг дараах аргачлалаар тооцов:

- Багийн хөдөлмөрийн зардал:
 - Нэг гишүүний цагийн хөлс $\times$ цаг $\times$ гишүүдийн тоо = $16,620 \times 1.0 \times 8$
 - $16,620 \times 1.0 \times 8 = 132,960$ MNT.
- Шатахууны зардал = 48,528 MNT.
- Багаж хэрэгслийн элэгдэл хорогдол = 12,781 MNT.
- Автомашины элэгдэл хорогдол = 6,575 MNT.
- Шууд зардал $(1+2+3+4) = 132,960 + 48,528 + 12,781 + 6,575 = 200,844$ MNT.
- Холбооны зардал $10\% = 200,844 \times 0.10 = 20,084$ MNT.

Онцгой байдлын байгууллагад ахуйн шинжтэй дуудлага өгсөн тохиолдолд иргэнээс Нийт зардал = шууд зардал + холбооны зардал = $200,844 + 20,084 = 220,928$ төгрөг гарахаар байна.

2.3.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

Дээрх тохиолдолд тохиолдлын тоог тодорхойлох боломжгүй бөгөөд 1 удаа ангийн байрлалаас гарч 1 цаг үүрэг гүйцэтгэхэд дунджаар **220.998** төгрөгийн зардал гарч байна. Энэхүү зардал нь томилгоот бүлгийн үүрэг гүйцэтгэх хугацаанаас хамаарна.

Тохиолдлын тоог бууруулах боломжтой бөгөөд иргэн бүр хариуцлагатай байх, шаардлагагүй тохиолдолд Онцгой байдлын байгууллагад дуудлага өгөхгүй байхад зардал буурах боломжтой юм.

ГУРАВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

“Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийн төрийн байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалтуудыг харгалзан тухайн байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтооход оршино.

Энэ хэсэгт Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төрийн байгууллагуудад үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагуудад буюу төрд хэдий хэр ачаалал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцоолно.

Хуулийн төслүүдэд тусгасан зардал дагуулах зохицуулалтуудаас төрийн байгууллагуудад буюу улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолох ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох;
- Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- Гарах зардлыг урьдчилан тооцоолох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах.

Аргачлалын 4.4.6-д заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандарт, кодчиллыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг тус тооцоонд оруулаагүй болно. Үүнд:

-10.7.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээг тогтоох журмыг Засгийн газар батална.

-28.1.12.онцгой байдлын албан хаагчийн гамшигтай тэмцэх тусгай зориулалтын хувцасны төрөл, стандарт, хэрэглэх зааврыг батлах.

-50.16.Гадаадын их, дээд сургуульд суралцагчид цалин хөлс олгох журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

-51.7.Энэ хуулийн 51.2, 51.5, 51.6-д заасан хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журмыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлд Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлж өгсөн бөгөөд Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах, шинээр зардал үүсгэх дараахь зохицуулалтыг тусгасан байна.

Хүснэгт 12. Зардалд нөлөөлөх зүйл, хэсэг, заалт

№	Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Хуулийн төсөл дэх шинээр үүрэг хүлээлгэсэн зохицуулалт
1.	29 дүгээр зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг. 29.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь чиг үүрэгтэй:	29.1.20.гамшигтай тэмцэх техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас хэрэгсэл, хүнсний болон шатахууны нөөц бүрдүүлэх.
2.	42 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоо	42.10.Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын тамгын газарт онцгой байдлын байгууллагын нэг алба хаагч ажиллана. 42.10.1.сумын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа алба хаагчийн зардлыг төр хариуцна.
3.		50.15.Онцгой байдлын байгууллагын захиалгаар гадаадын их, дээд сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлс болон ирэх, буцах нэг удаагийн тээврийн зардлыг төр хариуцна.
4.	50 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа	50.17.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
5.		50.18.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга тогтооно.

Хуулийн төслөөс зардал тооцохоор сонгосон дээрх 6 хэсэг, заалтын зардлыг 1.Хүний нөөцийн зардал буюу тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн алба хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал, 2. Материаллаг зардал буюу төрийн алба

хаагчийн ажлын байртай холбогдон гарах зардал, 3. Бусад зардал буюу тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд тогтмол хугацаанд дагалдан гарах зардлыг тоймлон тооцоолно.

